

**МОНГОЛ УЛС БОЛОН ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК
ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 12 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасныг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, төслийг хэрэгжүүлэх хугацааг урагшлуулах боломжтой эсэх, зээлийн эргэн төлөлтийг төлөхөд үүсэх ханшийн зөрүүг хэрхэн тооцох, төсөвт дарамт учруулах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд төслийг дэмжиж байгаа бөгөөд гадаадад эмчлүүлж байгаа иргэдийн тоо буурах, эрүүл мэндийн чанар, үйлчилгээний хүртээмж хэдэн хувиар нэмэгдэх талаар судалгаа хийсэн эсэх, бүсчилсэн хөгжлийн хүрээнд цаашид бусад бүс нутагт ижил төстэй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой эсэх, зүрх судас, хорт хавдраас урьдчилан сэргийлэх, оношилгоо хийх лаборатори шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат эрүүл мэндийн салбарын хувьд иргэддээ хүрч ажиллах, хариуцлага, үр дүнд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, зүрх судасны өвчлөл их байгаатай холбоотой гадагшаа гарах мөнгөн урсгалыг багасгах шаардлагатай, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн зээлийн хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбоотой гишүүдийн хэлсэн саналыг анхаарах, төслийг хэрэгжүүлснээр гадагш чиглэсэн мөнгөний урсгал саармагжих үр дүнтэй талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Г.ТЭМҮҮЛЭН

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, ~~болов~~ Европын сэргээн босголт, хөгжлийн банк ~~жөөрөндын~~ хооронд 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг